



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.1, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аялал жуулчлалын улирал эхэлж буйтай холбогдуулан Монголын бурхан шашинтны төв Гандантэгчилэн хийдийн дотор, гадна тал, суварга, үзмэрүүдийн цэвэрлэгээг Монголын Үндэсний Их сургуулийн Аялал жуулчлалын сургуультай хамтран 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /Б.Оюунзул/-д үүрэг болгосугай.

2. Цэвэрлэгээний материалын зардал болох 450,000 /Дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА